



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/1377

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлөөр олгосон эрх хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 0066632 дугаартай шийтгэлийн хуудас, 2020 оны 5 дугаар сарын 29-ний 02-18/100 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нүүр амны их эмч Бадамын Баяржаргалын ИЭ0014668 сери, 0014668 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс 3 сарын хугацаагаар хассугай.

2. Б.Баяржаргалын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрх хассантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:


2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг гурван сарын хугацаагаар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэх, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хассан талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Т.Учрал/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн /Д.Хишигбаатар/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Т.МӨНХСАЙХАН



141201330